

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дарьсүрэн	Дугаар	L322
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Бат-Өлзийт
Төрсөн газар	Бат-Өлзийт сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Гэсгүй лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Төвхөн хийд	Сүм хийдийн дугаар	ӨХБӨ 021
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 31	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын Төвхөн хийд

Жужа: Та энэ сүмийн талаар ярина уу?

Дарьсүрэн: Өө энэ хурлын тахил тахидаг дуган. Одоо энэ тэгээд жанрайсиг , намсрай, дамдин чойжоо бурхан ширээн дээр байна. Өнөөдөр 15 хурал хүрж байгаад сая тарлаа.Зүүн талын ширээн дээр нь болохоор махгал бурхан цагаан дарь эх , говийн лха бурхан гээд гэх мэтчилэн олон бурхан байна. Гол нь энэ мөнх зул барьдаг зул байна. Хойно нь далай лам, өндөр гэгээний зургууд байна.

Жужа: Энэ хүүчин Төвхөн хийдэд байсан бурхан байна уу?

Дарьсүрэн: Ер нь манай бүх юм 100 хувь устсан шүү дээ. Энэ махгал лхам хоёр байна, урд байсан үгүйг мэдэхгүй.Эрдэнэ зуугаас наашаа өгсөн. 1800 оны үед бүтээж байсан бурхдууд байдаг юм.

Жужа: Та Төвхөн хийдийн хүүчин түүхийн талаар яриарай?

Дарьсүрэн: Энэ 1653, 1654 оны үед өндөр гэгээн Занабазар 19 орчим насандаа Шивээт улаан ууланд ирж Төвхөн хийдийн анхны шавыг тавьж Дүб хан гэсэн хийдийг байгуулсан түүхтэй. Өндөр гэгээн өөрийнхөө нямба хийж байсан агуй нь дуган нь байдаг. Өндөр гэгээн бол өөрийнхөө сор болсон бүтээлүүдээ энд хийж байсан түүхтэй. Тэр зураг төслийг нь гаргаж байсан. Тэгээд тэрүүгээр дархны газар очиж одоо их гоё дахин

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

давтагдашгүй бүтээлээ хийж байсан.Тэгээд сүм хийд нурчихсан , сүйдчихсэн байхад нь Эрдэнэ зуугийн дээд ламтан гэж Дагвадаржаа гэж ламтан одоо энэ өндөр гэгээний барьсан дуганы гадна талаар модоор дуган барьж , урд талын энэ лаврин дуган бид нарын байгаа энэ дугануудыг барьж сайн ноён ханд хүлээлгэж өгч байсан. Дөрвөн лам суулгаж байгаарай гэж гуйж хүлээлгэж өгч байсан байна.

Жужа: Энэ хуучнаар хурлын дуган байсан уу, яг хэдэн лам байсан бэ?

Дарьсүрэн: Хуучин гучин долоон оны үед манай монгол лам ихтэй байсан байна. Энд нэг долоо, найман лам суудаг байсан байна. Тэгээд тэр сарын дүйчэн өдрүүдэд чинь шинийн найман, арван, арван таван, хорин есөн, битүүнд чинь бүр дугандаа багтаж шингэхгүй болдог байсан байна. Тэгээд хурал хурдаг тийм байсан байна.

Жужа. Тэр гэлэн лам нар байсан уу?

Дарьсүрэн: Хийд дээр байдаг улсууд нь гэлэн лам нар байсан байна. Хүрээний, нас өндөр болоод хүрэн дээр сууж байсан өндөр настан лам нар бас сарын дүйчэн өдрүүдээр ирж хурал хурж байсан байна.

Жужа: Тэгээд энэ Жамъян гэлэн гэж...?

Дарьсүрэн: Энэ 1930-аад оны үед Жамъян гэлэн гэдэг хүн зүүн зүгээс, одоогоор бол булган , Төв аймаг л юм байна л даа. Тэр 11 жил нямба хийх гэж ирээд, тэгээд нямбаны агуйд лам нар дүүрчихсэн.Тэгээд одоо суух байр байхгүй. Хийдийн тэр удирдах ламаар зөвшөөрөл аваад мод хагалдаг хоёр сүхээр ухсан байдаг юм. Тэгээд хүний гараар ухсан агуй гээд байдаг. Тэгээд тэр Жамъян гэлэн тэр агуйг сүхээр ухсанаараа буруудаж хийдийн лам , Жамъян гэлэн тэр хоёр шийтгэл авч байсан байна.

Жужа: Хийдийг хэзээ нураасан бэ?

Дарьсүрэн: Хийдийг 1937 оноос хар тэрэгтэй улсууд ирээд хамаг алт мөнгийг нь аваад тэгээд галдан шатаасан.

Жужа. Гамин цэрэг ирсэн үү?

Дарьсүрэн: Гамин цэрэг ирж байсан.

Жужа: Хийдийн гол шүтээн?

Дарьсүрэн: Богд лам, бурхан багш, махгал шүтээнтэй.

Жужа: Хэдэн онд сэргээсэн бэ?

Дарьсүрэн: 1993 онд сэргээсэн.

Жужа: Ямар ямар дугантай вэ?

Дарьсүрэн: 5 дугантай. Лаврин дуган, богдын, хурлын, тахилын дуган. Баруун талын энэ цоохор синжийн дуган.Тэнд хурал хурахгүй. Том хувилгаантан ирвэл хүлээж авна.

Жужа: Ямар хурал хурж байна вэ?

Дарьсүрэн: Байнгын цогчин хурал хурна.

Жужа: Сарын дүйчэн өдрүүдэд?

Дарьсүрэн: Сая авидын чог хурлаа.Шинийн найманд манал хурдаг юм.Бусад цагт нь сандуйн жүд хурдаг юм.

Жужа: Та ер нь ганцаараа суудаг тийм ээ?

Дарьсүрэн: Байнгын суудаг нь би л дээ.Бусад нь ээлжээр суудаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хүүхдүүд хаанаас ирдэг вэ?

Дарьсүрэн: Ганданг хийдийн идгаа дацангаас.

Жужа: Төвхөн хийдийн тойронд ямар ямар газрууд байна вэ?

Дарьсүрэн: Юмын агуй, махгал мод, дарь эх мод, холбоо мод гээд байгалийн их гоё гоё газруудтай.

Жужа: Сүсэгтэн их ирэх үү?

Дарьсүрэн: Ер нь их ирнэ. Зуны 7 сар, 8 сар, 9 сард их ирнэ. Өвөл ч жуулчид ирнэ.

Жужа: Энэ гурван суварга ямар суварга байна вэ?

Дарьсүрэн: Гурвуулаа бодь суварга. Дунд талынх нь Өндөр гэгээний өөрийнх нь бүтээсэн. Нутгийн Ганхуяг гэж хүн сэргээн засварласан.

Жужа: Хуучны гучин найман оны лам нар байгаа юу?

Дарьсүрэн: Байхгүй. Ганц Бодьгэрэл гэж хүн байсан 2 жилийн өмнө нас барчихсан. 7-12 насандаа сууж байсан өвгөн байсан юм.

Жужа: Цаашдын төлөвлөгөө?

Дарьсүрэн: Манайх дэлхийн ЮНЕСКО ийн дэлхийн өвд орчихсон. Хуучнаар нь яг байлгана гээд. Бид нар бас нэг мөргөлчдөд зуны цагт бас үйлчлэх жижигхэн ундаа усны юм барьж байгаа л даа. Энэ бас шүүмжлэгдэж байгаа.

Жужа: Гадаад жуулчид ирдэг үү?

Дарьсүрэн: Гадаад жуулчид их ирдэг. Дэлхийн өвд их бүртгэж интэрнетэд тавьчихдаг юм байна. Тэрүүгээр нь энд юу байна гэдгийг нь бүгдийг мэддэг.

Жужа: Тэр дуганд хурал хурдаг гэсэн, тийм ээ?

Дарьсүрэн: Тэгнэ, хурал хурна. Маанийн бүтээл бүтээхдээ лам нар багтахгүй болохоор тэр дугандаа тахилаа хурчихдаг юм.

Жужа: За баярлалаа.

Дарьсүрэн: За баярлалаа.